

**“АХМАДЫН ХОТХОН-1” ОНӨААТҮГ-ЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот:

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	Биелэлт хувь
ЗГҮАХ-ийн 2.3.2 дагуул хаяа хот, тосгон, дэд төвүүд шинэ суурьшлын бүсийг цогцоор нь хөгжүүлж, орлогод нийцсэн орон сууц, түрээсийн орон сууцыг хөгжүүлэх, залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	1.1 Ахмад настан, гачигдалтай, хөгжлийн бэрхшээлтэй болон дахин төлөвлөлтөд хамрагдан хохирсон иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна	1. Сүхбаатар дүүрэг 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Баярс констракшн" ХХК-ний шинээр ашиглалтанд оруулсан түр суурьшуулах 156 айлын орон сууцыг хүлээн авах бэлтгэл ажлыг хангах	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо Цагдаагийн гупамжинд шинээр ашиглалтанд орох 813 “Б” блоккийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Баярс констракшн” ХХКомпани 2018.12.08-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. “Ахмадын хотхон-1”ОНӨААТГ-аас орон сууц хүлээн авах бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Захирамж, шийдвэр гарахыг хүлээж байна. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1090 дугаартай захирамжаар Сонгинхайрхан дүүргийн 19 хороо 21 дүгээр хороололд шинээр ашиглалтанд орсон 70 айлын түрээсийн орон сууцанд хуваарилагдсан 51 айлд олгогдсон батламжийн дагуу гэрээ байгуулж өнөөдрийн байдлаар 30 айлтай гэрээ байгуулж орон сууцыг хүлээлгэн өгөөд байна.	90
	1.2 Хот, нийтийн аж ахуйн чиглэлийн газруудын үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллана.	1.Хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгох "Дотоод хяналт шалгалтын журам" боловсруулж, батална.	Дотоод хяналт шалгалт, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр гарган батлаж, эхний хагас жилийн биелэлтийг 2018 оны 74 дугаартай албан тоотоор, жилийн эцсийн биелэлтийг 147 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж ажилласан. Захирагчийн ажлын албанаас мөрдүүлж буй нийтлэг журмыг хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.	100

№	БАЙГУУЛЛАГ ЫН ДҮРЭМД ЗААГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	Биелэлт хувь
2	Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	2.1 "Ахмадын орон сууц" -ны оршин суугч, болон түрээсийн орон сууцанд орсон иргэдийн судалгааг гарган, оршин суугчдын хөдөлгөөний мэдээллийг боловсруулж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх	Сар бүрийн 25-ны дотор тус хотхоны оршин суугчдын хөдөлгөөний судалгааг нийслэлийн Захирагчийн ажлын албаны орон сууц хариуцсан мэргэжилтэн Д.Шийтэрийн shiiter.do@gmail.com цахим хаягаар сар бүр мэдээ хүргүүлж, 2018 онд нийт 22 айл өрхүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр нийслэлийн Захирагчийн ажлын албанд гаргасан өргөдөл, холбогдох материалын хамт хүргүүлж 5 айлын асуудлыг шийдвэрлүүлж, 17 айлыг дүүргийн Орон сууцны комиссоор шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн.	90
		2.2 "Ахмадын орон сууц" - ыг тусгай нөхцөлтэйгөөр хөлслүүлэх гэрээнд сунгалт хийж, оршин суугчдын мэдээллийг шинэчлэх	Хотхоны 901 дүгээр байрны 127 айл, 902 дугаар байрны 124 айл нийт 251 өрхтэй орон сууц түрээслэх гэрээг шинээр байгуулж, одоогийн байдлаар 84,2 хувийн биелэлттэй байна. Батлан даагч солих, орон сууцны тооцоо нийлэх болон эрх шилжүүлэхтэй холбоотой асуудлаар үлдсэн айлуудтай гэрээ шинэчлэх боломжгүй байгаа болно.	90
		2.3 Хотхоны оршин суугч иргэдийг гэрээнд заасан тусгай нөхцлийг зөрчихөөс урьдчилан сэргийлж, улирал бүр хяналт шалгалт явуулах	2018 оны эхний 9 сард түрээс болон ашиглалтын төлбөрөө хугацаандаа барагдуулаагүй айл өрхүүдэд мэдэгдэл өгч нийт 4,2 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 902 дугаар байрны 46 тоот оршин суугч иргэн М.Должинсүрэнтэй холбоотой орон сууцны төлбөрийн талаарх иргэний хэрэг маргаан үүсгэхээр Баянгол дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, цаашид оршин суугч иргэдийг гэрээнд заасан хугацаанд төлбөрөө барагдуулж байх, гэрээний хориглосон заалтыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч Төрийн банктай гэрээ байгуулж биллэр үйлчилгээг нэвтрүүлж, алданги тооцож ирсэнээр төлбөр төлөлт хугацаандаа хийгдэж байх нөхцлийг бүрдүүлсэн.	90
		2.4 Гэрээ дуусгавар болж чөлөөлөгдсөн орон сууцыг хүлээн авч хэвийн нөхцөлийг хангуулж дараагийн түрээслэгчтэй гэрээ байгуулан хүлээлгэн өгөх.	2018 оны жилийн эцсийн байдлаар эрхийн бичиг цуцлагдаж, гэрээ дуусгавар болж чөлөөлөгдсөн 2 иргэний орон сууцыг хүлээн авч дараагийн иргэнтэй гэрээ байгуулж орон сууцыг хүлээлгэн өгсөн. Шийдвэрлэх шаардлагатай хүлээгдэж буй айлуудын асуудлыг нийслэл, дүүргийн Орон сууцны сонгон шалгаруулах комисстой хамтран ажиллаж байна.	70

		<p>2.5 Нийслэлийн Гэр хороолол, дэд бүтцийн газартай түр суурьшуулах 132 айлын, гэрээг шинэчлэн байгуулж, хамтран ажиллах</p>	<p>Нийслэлийн Гэр хороолол, дэд бүтцийн газартай түр суурьшуулах 132 айл, өрхийн орон сууцны ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллах гэрээг шинэчлэн байгуулах санал хүргүүлсэн хариу ирүүлээгүй тул НӨХГ-ын даргын 2018 оны А/230 дугаар тушаалын дагуу ОСНААУГ-ын ХҮ-5 төвд орон сууцны ашиглалт үйлчилгээг шилжүүлж оршин суугчидтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.</p>	<p>90</p>
		<p>2.6 Шинээр барьж ашиглалтанд оруулах түрээсийн 156 айлын орон сууцны ашиглалт засвар үйлчилгээг хариуцан ажиллах бэлтгэл ажлыг хангуулах.</p>	<p>Барилгыг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Хотын Ерөнхий менежерээр ахлуулсан ажлын хэсэг гүйцэтгэгч “Баярск констракшн” ХХК-ны удирдлагыг байлцуулан барилгын ажилтай танилцаж 2018 оны 12 дугаар сарын 08-ны өдөр улсын комисс хүлээн авсан. Холбогдох эрх бүхий шийдвэр гарсан тохиолдолд барилгыг хүлээн авах бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан.</p>	<p>90</p>
		<p>2.7 Түрээсийн орон сууцанд шинээр суурьших 156 айлын орон сууцанд хамрагдсан иргэдтэй орон сууц хүлээлцэж, оршин суугчдын судалгааг гаргаж, гэрээ хийх.</p>	<p>Гэр хорооллын дэд бүтцийн газартай гэрээ байгуулж түлхүүрээ барьж ирсэн нийт 15 айлд орон сууцны эд хөрөнгө хүлээлцэх акт үйлдэж хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгуулсан. Оршин суугчдын судалгааг гаргаж ОСНААУГ-ын харъяа хэрэглэгдэд үйлчлэх 5 дугаар төвд шилжүүлж гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулсан.</p>	<p>90</p>
		<p>2.8 Түрээс болон ашиглалтын зардлын төлбөр тооцооны хуудсыг хэвлэн, оршин суугчдад тарааж, төлбөр төлөлтөнд хяналт, шаардлага тавьж ажиллах</p>	<p>Түрээс болон ашиглалтын зардлын төлбөр тооцооны хуудсыг хэвлэн, оршин суугчдад тарааж 12 дугаар сарын 01-ны байдлаар 383,3 сая төгрөгийн орлого хийгдсэн төлбөр төлөлт хэвийн байна.</p>	<p>90</p>
		<p>2.9 Олон улсын ахмадын өдрөөр тус хотхонд амьдарч буй 80-аас дээш насны ахмадуудад хүндэтгэл үзүүлэх.</p>	<p>Сар шинийн баярыг тохиолдуулан тус газрын даргын 2018 оны А/04 тоот тушаалаар Ахмадын хотхон-д амьдарч буй харж хандах хүнгүй, ганц бие ахмад настны судалгааг гаргаж, 901 дүгээр байрны 45 тоотод оршин суугч О.Долгор, 54 тоотын Ц.Дэмбэрэлдорж, 100 тоотын Д.Алтангэрэл, 902 дугаар байрны 11 тоот Ж.Долгорсүрэн, 17 тоот Ж.Цэрэндорж, 46 тоот Д.Сүрэнжав, 50 тоот Б.Шоовдор, 60 тоот Ж.Базарсад, 91 тоот Ч.Нүрээд, 96 тоот С.Түмэн-Өлзий, 58 тоот Д.Дэнсмаа, 901 дүгээр байр 7 тоот З.Мандах, 25 тоот Д.Пунсал, 32 тоот Ё.Мөнхчулуун нарын өндөр настанд хадаг, хэвийн боов, суурь еэвэн, тавгийн чихэр, гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ. Олон улсын ахмад настны эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 901, 902 дугаар байрны 80 наснаас дээш 16 ахмад настан, байгууллагын 2 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлсэн</p>	<p>100</p>

3	Хотхоны барилга байгууламжийн дулаан, цахилгаан, инженерийн шугам, сүлжээний хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах .	3.1 УДДТөв, инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны худгууд, хотхоны байруудын орц, гарааш, узелүүдэд ээлжит техникийн үзлэг хийж, хийгдэх засвар үйлчилгээний жагсаалт гаргах	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 06 сарын 06 -ны өдрийн "Ахмадын хотхон-1"ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай А/230 дугаар тушаалын дагуу ОСНААУГазарт УДДТөв, инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны худгуудыг хүлээлгэн өгсөн. Тайлбар: <i>Иймд энэ засварын ажлыг хийж гүйцэтгэх шаардлагагүй болсон.</i>	100
		3.2 Хотхоны байруудын цахилгаан шатыг баталгаажуулж, мэргэжлийн байгууллагаар техникийн магадлал хийлгэх	"Улаанбаатар лифт" ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу 813, 901, 902 дугаар байрны нийт 8 лифтуудад 2018.03.13-ны өдрийн 10/20/18 дугаартай техникийн магадлал хийлгэж ашиглалт үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг хангуулан ажиллаж байна.	90
		3.3 Гадна ариутгах татуурганы худагт үзлэг хийж шугам хоолойг лайдаж, тусгай тоноглолтой автомашин дуудлагаар авч ажиллуулан, даралттай усаар угааж, цэвэрлэх	Сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд хотхоны эзэмшлийн 26 худагт цэвэрлэгээ хийж laidан бохирын шугам хоолойд үзлэг хийж, 2018.01.07-ны өдөр УСАУГ-аас 1 удаа тусгай тоноглолтой автомашин дуудлагаар авч ажлуулан, даралттай усаар угааж бөглөрөл үүсгэлгүй ажиллаж оршин суугчдын тав тухтай орчныг бүрдүүлж ажилласан. Тайлбар: <i>2018 оны 07 сарын 01-ээс "Ахмадын хотхон-1"ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай НӨХГ-ын А/230 дугаар тушаалын дагуу ус дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээг Хэрэглэгчдэд үйлчлэх 5 дугаар төвд шилжүүлсэнээр энэ засварын ажлыг хийж гүйцэтгэх шаардлагагүй болсон.</i>	90
		3.4 Оршин суугчдаас ирүүлсэн цахилгаан, сантехникийн дуудлагыг хүлээн авч, инженер техникийн ажилчдаар чанарын өндөр түвшинд шуурхай засварлуулах арга хэмжээг зохион байгуулах.	Эхний хагас жилд оршин суугчдаас ирүүлсэн цахилгаан-62, сантехникийн-350 нийт 412 удаагийн дуудлагыг хүлээн авч, инженер техникийн ажилчдаар чанарын өндөр түвшинд шуурхай засварлуулах арга хэмжээг зохион байгуулж оршин суугчдын тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж ажилласан. Тайлбар: <i>2018 оны 07 сарын 01-ээс "Ахмадын хотхон-1"ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай НӨХГ-ын А/230 дугаар тушаалын дагуу ус дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээг Хэрэглэгчдэд үйлчлэх 5 дугаар төвд шилжүүлсэнээр энэ засварын ажлыг хийж гүйцэтгэх шаардлагагүй болсон.</i>	90

		3.5 Хотхоны 901, 902 дугаар байрны коридор, шатны гэрэлтүүлгийг шинэчлэх	Хотхоны 901, 902 дугаар байрны коридор, шатны гэрэлтүүлгийг шинэчлэхэд нийт 1,5 сая төгрөг зарцуулж 78 ширхэг мэдрэгчтэй лед гэрэл, гадна талбай, орчны үүдэнд 5 ширхэг лед паржуктор, лед гэрэл авто гараашид 16 ширхэг хасах гэрэл тус тус суурилуулж орчны гэрэлтүүлгийг сайжруулах арга хэмжээ авсан.	90
		3.6 Хотхоны 901, 902 дугаар байрны айл өрх, авто гараашийн галын дохиоллын системийн найдвартай ажиллагааг хангуулах, ослын гэрэлтүүлгийг монтажыг шинэчлэн засварлах	Хотхоны 901, 902 дугаар байрны айл өрх, авто гараашийн галын дохиоллын системд шалгалт хийж, аваар ослын үед найдвартай ажиллагааг хангуулах, ослын гэрэлтүүлгийг шинэчлэх, авто гараашийн гэрэлтүүлгийг шинэчлэх, галын хорыг цэнэглэх арга хэмжээг зохион байгуулсан. Айл өрхийн галын дохиоллын мэдрэгчийн хэвийн ажиллагааг мэргэжлийн байгууллагаар засварлуулахаар шийдвэрлэсэн	70
		3.7 Оршин суугчдын орон байрны дулааны алдагдал хэмжигч төхөөрөмж худалдан авч орон сууцны дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	Орон байрны дулааны алдагдал хэмжигч /INFRARED THERMOMETER DT8380/ төхөөрөмж худалдан авч түр суурьших 813 дугаар байрны айл өрхүүдэд хэмжилт хийж оршин суугчдад орон байрных нь аль хэсэгт дулаан алдагдаж байгаад хэмжилт хийн дулаалга хийх зөвлөгөө өгч, барилга үйлдвэрлэлийн явцад бий болсон дулаан алдагдлыг барилга угсралтын ажил гүйцэтгэсэн “Баярск констрагшн”ХХК-иар чигжээс хийлгэх цонх, халаалтын радиотор солиулах зэрэг ажлыг хийлгэж дулаан алдагдлыг бууруулах, арга хэмжээ авч ажилласан.	90
		3.8 Хотхоны 901,902 дугаар байрны доорх авто гараашийн шал цутгах, ханыг будаж тохижилт хийх	901, 902-р байрны гараашийн шал цутгах ажлыг 2018 оны 9-р сарын 17-ноос 10 дугаар сарын 15-ныг хүртлэх хугацаанд хийж автомашины зогсоолуудыг номерлож дугаарлав. Мөн халаалт авахтай холбогдуулан шат орц хонгил гараашийн шугам хоолойд үзлэг шалгалт хийж шаардлагатай хаалт арматурыг сольж халаалт авав.	90
		3.9 Хотхоны 901,902 дугаар байрны гадна фасад засварлах ажлын зураг төсөв хийлгэх, 2019 оны төсөвт тусгуулах ажлын саналыг НӨХГ-т хүргүүлэх	Хотхоны 901,902 дугаар байрны гадна фасад засварлах ажлын зураг төсөв хийлгэх тухай саналыг 148 дугаартай албан тоотоор 2019 онд өөрийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулах төлөвлөгөөнд тусган НӨХГазар, Худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлсэн.	90

		3.10 Хотхоны 901,902 дугаар байрны нийтийн эзэмшлийн хана, тааз, шатны хөндийд их засвар хийх	Засварын ажлыг оршин суугчдын санал хүсэлтийн дагуу зусланд гарсан хүн цөөтэй байх үеийг бодолцон 7 сард хийхээр шийдвэрлэж 2018 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн Зууны мэдээ сонины №120 дугаарт болон Зар мэдээ сонины 2018 оны 6 дугаар сар 12-15-ны өдрийн №40 дугаартай хэвлэлтэнд ажил гүйцэтгэгч сонгох үнийн санал ирүүлэх зарыг байршуулж “Би Эн Ти Жи” ХХКомпаниар 17,9 сая төгрөгийн засварын ажлыг хийлгүүлж гүйцэтгэлийг 2018 оны 07 сарын 25-ны өдөр хүлээн авсан.	90
		3.11 Хотхоны 901,902 дугаар байрны гадна хаалга, конторын цонх хаалгыг шинэчлэх.	Хотхоны 901,902 дугаар байрны гадна хаалгыг домофон систем бүхий цоожтой хаалгаар сольж оршин суугчдад цахим түлхүүр /чип/-тэй болгох арга хэмжээ авч хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэнэмэл хүн орцонд хоноглохоос сэргийлэх арга хэмжээг 2 ширхэг хаалганд 1сая 67 мянга, домофон цоожинд 1 сая 905 мянган төгрөг нийт 3.137,000 төгрөг зарцуулсан.	100
4	Хотхоны нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг сайжруулах зорилгоор тохижилтын төлөвлөгөө гарган, оршин суугчдын эрүүл,	4.1 Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Баярс констракшн ХХК-ний шинээр ашиглалтанд оруулах 156 айлын орон сууцны нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах ажлыг зохион байгуулах	Түр сууршуулах 813 дугаар байрны зүүн талд улиас 12ш, гацуур 5ш, хус 4ш, нийт 21 ширхэг моднуудыг “Навчит ой” ХХК-иас тарьц худалдан авч суулган ногоон байгууламж шинээр байгуулах ажлыг тус тус зохион байгууллаа.	90
		4.2 Оршин суугч иргэдийн оролцоотойгоор хотхоны нийтийн эзэмшлийн зам талбайн нийтийн их цэвэрлэгээг үе шаттайгаар зохион байгуулж, хог хаягдлыг бууруулах, хэрхэн ангилал талаар мэдээлэл сурталчилгаа явуулах	Оршин суугч иргэдийн оролцоотойгоор Сар шинийн баярыг тохиолдуулан хийгдэх 2 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд их цэвэрлэгээг зохион байгуулж дундын эзэмшлийн хана туурга, хаалгаа угааж цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулж, иргэд оршин суугчид 150 гаруй хүн, байгууллагын 18 ажилтан, нийт 168 хүн 901,902,813 дугаар байруудын шатны хөндий, болон цахилгаан хуваарилах самбар, лифт орчмын хана, цонхуудыг угаах нэгдсэн хуваарь гаргаж нийт 3274м2 талбай бүхий хана, шатны хөндийг угааж цэвэрлэн, коридорт 52 ширхэг лед гэрэл шинээр суурилуулж, орцны гэрэлтүүлэг өнгө үзэмжийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулсан.	90
	4.3 Хотхоны нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, цэцэрлэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нийтийн эзэмшлийн зам талбай дахь харшлын өвчин үүсгэгч	Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГазраас 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 901,902 дугаар байрны гадна талбайд өмнөх онуудад тарьсан моднуудад арчилгаа хийж модны тогоог сэргээн усалгаа хийж, түр сууршуулах	90	
	аюулгүй, цэвэр тохилог орчинг			

бүрдүүлнэ.	ургамлыг устгах ажлыг зохион байгуулж, тоосонцрын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах	813 дугаар байрны зүүн талд улиас12ш, гацуур 5ш, хус 4ш, нийт 21 ширхэг моднуудыг “Навчит ой” ХХК-иас тарьц худалдан авч суулган ногоон байгууламжийг шинээр байгуулах ажлыг тус тус зохион байгуулж, “Үндэсний мод тарих өдөр”-ийн нэгдсэн арга хэмжээнд тус байгууллагаас 22 ажилтан, мөн 901, 902, 813 дугаар байруудын оршин суугч нар мод тарих ажилд хамтран идэвхитэй оролцон мод тарихад шаардлагатай элс хайрга суулгацаа 2 тээврийн хэрэгсэл татан авч энэ арга хэмжээнд нийт 1,6 төгрөг зарцуулж тохижилтын ажил хийгдсэн. Цаашид харшил үүсгэгч зэрлэг ургамал ургахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.	
	4.4 Эрүүл ахуйн тухай хуулийн дагуу Хотхоны оршин суугч айл өрхүүдэд ахуйн шавьж, мэрэгч амьтны устгал явуулах арга хэмжээг зохион байгуулах	Хотхоны 901,902 дугаар байрны оршин суугч айл өрхүүдэд мэрэгч амьтны устгал явуулах ажлыг 2018.06.16-ны өдөр зохион байгуулсан. Ариутгал халдваргүйжүүлэлт, ахуйн шавьж, мэрэгч амьтны устгал хийдэш Ариун ус ХХК-ний зөвөлсөнөөр 2018 оны 9 дүгээр сарын15-20-ны өрүүдэд шавьжны устгалыг айл өрхүүдэд хийж ахуйн шавьж, мэрэгч амьтны устгал явуулсан.	100
	5.1 "Иргэдийн оролцоотой- Амьдрах орчиныг сайжруулах жил"-ийн хүрээнд оршин суугч иргэдийн санал хүсэлтийг авч, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	"Иргэдийн оролцоотой- Амьдрах орчиныг сайжруулах жил"-ийн хүрээнд оршин суугч иргэдийн санал хүсэлтийг оршин суугчидтай гэрээ сунгах арга хэмжээний үеэр хүлээн авч 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаартай албан бичигээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтэст нэгдсэн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх 7 ажлын саналыг хүргүүлж, байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний биелэлт -90,5%-тай биелсэн.	90

5	Байгууллагын үйл ажиллагааны чанар, соёл, хүртээмжийг сайжруулна.	5.2 Байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулах төслийн саналыг боловсруулж хүргүүлэх, батлуулах	Байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж 2018.01.15-ны өдрийн 04 дугаартай албан тоотоор нийслэлийн Захирагчийн ажлын албанд саналаа хүргүүлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлах тухай ” 14/01 дүгээр тогтоолын “3.2.6. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуу гэр бүл, нийгмийн зорилтот бүлэгт зориулсан түрээсийн болон түр суурьшуулах орон сууцны санг бий болгох;” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/78 дугаар тушаалын дагуу ахмадын орон сууц хөтөлбөрт хамрагдах иргэдийг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт Гэрээний мэргэжилтэн Г.Баатархүүг томилуулж журмын төсөлд саналаа хүргүүлээд байна.	30
		5.3 Байгууллагын 5 жилийн ойг угтаж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж ой тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	Байгууллагын 5 жилийн ойг угтаж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж ой тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2018 оны “Баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/31 дугаартай тушаалын дагуу 1,360,000 төгрөгийн төсөв зарцуулж ой тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.	100
		5.4 "Хэрэглэгчдээ сонсьё" нээлттэй хаалганы өдөрлөгийг ХСУХАТАҮЗЗөвлөлтэй хамтран зохион байгуулж иргэд, оршин суугчдыг хэрэглээний халуун, хүйтэн усны хэрэглээний талаарх мэдээллээр хангах.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 03-р сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Улаанбаатар хотын хүн амд мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф"-ыг хотхоны оршин суугч иргэдэд танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. "Хэрэглэгчдээ сонсьё" нээлттэй хаалганы өдөрлөгийг ХСУХАТАҮЗЗөвлөлтэй хамтран 2018 оны 10 дугаар сарын 09-ны өдөр ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх 5 дугаар төвийн инженер техникийн ажилтангуудтай хамтарч оршин суугч иргэдийн халуун хүйтэн усны тоолуурыг нэгдсэн журмаар баталгаажуулах арга хэмжээ авч, үйлчилгээний үнэ тарифын талаар мэдээлэл өгч ус дулааны эрчим хүчээр хангах ашиглалт үйлчилгээний гэрээг шинээр байгуулсан.	100
		5.5 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулж иргэд, олон нийтэд хүргэх	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудасны Онцлох мэдээ, цаг үеийн мэдээ, цэсүүдээр дамжуулж иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.	90

		5.6 Байгууллагын санхүүгийн мэдээллийг өөрийн шилэн дансны цахим хуудас болон, мэдээллийн самбарт байршуулан ил тод байдлыг хангах	Шилэн дансны мэдээллийн төрөл тус бүрээр сар бүр мэдээллийг байршуулж, мэдээллийн самбарыг шинэчлэн хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна.	90
		5.7 ХЕМ-ийн шуурхай хуралдаанд хуваарийн дагуу оролцож, үүрэг даалгаврыг хэрэгжилт үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.	2018 онд Хотын удирдах ажилтны шуурхай хуралд 23 удаа, Хотын Ерөнхий Менежерийн шуурхай хуралдаанд 25 удаа оролцож, өгөгдсөн үүрэг даалгавруудаас байгууллагын үйл ажиллагаатай холбогдол бүхий заалтуудын дагуу биелэлтийг гарган давхардсан тоогоор 32 удаагийн хурлаас өгсөн үүргийн биелэлтийг monitoring@ub.service.mn , zaa.Monitoring@yahoo.com цахим хаягаар хүргүүлж, нэгдсэн удирлага зохион байгуулалтаар хот нийтийн аж ахуйн чиглэлээр хийгдэж буй ажлын мэдээнд тусгуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.	90
6	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах таатай орчинг бүрдүүлнэ.	6.1 Ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэж, урамшуулах арга хэмжээг зохион байгуулах	Байгууллагын ажилчидтай хийсэн хөдөлмөрийн гэрээг хагас жилээр дүгнэж урамшуулах "Ажлын хэсэг байгуулах тухай" А/14 дугаартай тушаал гарган 2018 оны 06 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд зохион байгуулж байгууллагын даргын А/17 тушаалаар урамшуулал олгосон Жилийн эцсийн ажлыг 2018.12.25-нд дүгнэхээр ажлын хэсэг гарган ажиллаж байна.	100
		6.2 Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан болон ажилчдын дунд соёл спортын арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхийг дээшлүүлэх	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан Цасны баяр нэгдсэн арга хэмжээний хүрээнд олс таталт, цасны сумо, уулын оргилд булаалдах зэрэг тэмцээн, "Улаанбаатар Марафон"-д нэгдэцгээе уриан дор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цомийг 2018 оны 04 дүгээр сарын 2-4-ны өдрүүдэд аялуулж ажилчдын дунд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, дартс зэрэг спортын төрлүүдээр уралдаан тэмцээн зохион байгуулж, 2018 оны 05 дугаар сарын 19-ны өдөр "Улаанбаатар марафон-2018" олон улсын марафон тэмцээний 5 километрийн зайд харуул хамгаалалтын ажилтан Н.Мөнхбат оролцож батламж авсан.	100
		6.3 Ажилчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, эрүүл мэндийн аяны хүрээнд, халдварт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Байгууллагын ажилчдыг эрүүл мэндийг сахин хамгаалах, эрүүл мэндийн аяны хүрээнд, халдварт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг 2018.11.02-ны өдөр Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж нийт 24 ажилтанг үзлэгт бүрэн хамруулсан.	100

		<p>6.4 Ажилчдыг дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, семинарт болон мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулж, боловсон хүчний мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлж ажиллах</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс, Гадаад харилцааны яамтай хамтран нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд болон гадаад харилцааны асуудал хариуцсан албан хаагчдад зориулан Монгол улсын төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах нь сэдэвт сургалтанд 1 ажилтан, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Удирдлагын Академтай хамтран “Байгууллагын хөгжил, харилцааны ур чадвар” сэдэвт богино хугацааны 16 цагийн сертификаттай сургалтанд 1 ажилтан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг баталсантай холбогдуулан www.ublegal.mn цахим хуудсыг шинэчлэхтэй холбоотой мэдээлэл өгөх сэдэвт сургалтанд 2 ажилтан, Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-аас зохион байгуулсан уулзалт зөвлөлгөөнд 1 ажилтан, “Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, цахим системд мэдээллээ хэрхэн шивэх, анхаарах асуудлын талаархи” сэдэвт сургалтанд 2 ажилтан, Худалдан авах ажиллагааны газраас цахим систем ашиглалтын тухай сургалтанд 1 ажилтан, нийслэлийн Мэдээллийн технологийн газарт Нийслэлийн шилэн тендерийн бүртгэлийн системийн сургалтанд 1 ажилтан, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Ус сувгийн удирдах газар хамтран Захирагчийн харьяа байгууллагуудын дунд анх удаа зохион байгуулж буй “захиргаа, хүний нөөц, дотоод хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт” сэдэвт сургалтад 1 ажилтан, "УСУГ ОНӨААТҮГ"-т зохион байгуулагдсан сургалтанд 1 ажилтан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхийг бэхжүүлэх нь” сургалтанд 1 ажилтан Нийслэлийн Засаг даргын А/107 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудыг холбосон нэгдсэн UBSMART ERP цогц системийг хөгжүүлэх нэвтрүүлэхтэй холбогдуулан системийн сургагч багш бэлтгэх сургалтанд 2 ажилтан, Нийслэлийн Архивын газраас Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн ашиглалт, хэрэглээ сэдэвт сургалтанд Архив, бичиг</p>	<p>100</p>
--	--	---	---	------------

			хэргийн ажилтан хамрагдав. Нийслэлийн Засаг даргын А/252 захирамжийн дагуу хэрэгжиж буй Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн 3-р хувилбарын хэрэглээ, ашиглалтыг сайжруулах нь сэдэвт сургалтанд 1 ажилтан, нийт 13 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 15 ажилтныг сургалтанд хамруулж мэдлэг боловсролыг нь дээшлүүлсэн.	
7	Байгууллагын үйл ажиллагааны үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайланг гарган холбогдох газруудад хүргүүлж, дүгнүүлэх	7.1 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, биелэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэх	2017 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, эхний хагас жилийн биелэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст жилийн эцсийн биелэлтийг 2018.12.25-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна.	90
		7.2 Төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтийг гаргаж хүргүүлэх	Төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтийг гаргаж 2018.06.25-ны дотор албан тоотоор нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, жилийн эцсийн байдлаар гарган 2018.12.10-ны өдрийн 147 дугаартай албан тоотоор Нийслэлийн Захирагчийн ажлын албанд тус тус хүргүүлсэн.	100
		7.3 Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээг гаргаж хүргүүлэх	Эхний хагас жил, эхний 9 сарын байдлаар байгууллагад холбогдол бүхий зүйл заалтыг бүртгэн авч хэрэгжилтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан тоотоор хүргүүлсэн, 2018 оны жилийн эцсийн тогтоол шийдвэрийн биелэлтийг батлагдсан загварын 2018.12.20-ны өдрийн 156 албан тоотоор хүргүүлсэн.	90
		7.4 Нийслэлийн удирдлагаас өгсөн үүргийн биелэлтийг гаргаж хүргүүлэх	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай, Хотын Ерөнхий менежерийн хуралдаанаас өгөгдсөн байгууллагатай холбогдол бүхий заалтын хэрэгжилтийг хангуулж давхардсан тоогоор 32 удаагийн өгсөн үүргийн биелэлтийг гарган цахим шуудангаар хүргүүлж ажилласан.	90
		7.5 Байгууллагын санхүүгийн хагас бүтэн жилийн тайлан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Байгууллагын 2018 оны санхүүгийн хагас жилийн тайланг гарган 2018 оны 07 дугаар сарын 05-ны дотор хүргүүлж, жилийн эцсийн биелэлтийг 2019.01.25-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна.	90

		7.6 Тус газрын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг гаргаж холбогдох газруудад хүргүүлэх	Тус газрын 2018 оны эхний хагас жил, жилийн эцсийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг гарган нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 2018.12.31-ны 160 дугаартай албан тоотоор хүргүүлэхээр ажиллаж байна.	100
		7.7 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилсэн стандартад нийцүүлэн шинэчлэх	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилсэн стандартад нийцүүлэн шинэчлэж, нэмэлт өөрчлөлтийг даргаар батлуулж, бодлогын бичигт хавсарган мөрдөж ажиллаж байна.	100
		7.8 Байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай үндсэн хөрөнгийг худалдан авах, хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гаргаж баталгаажуулсан байх	Байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай үндсэн хөрөнгө худалдан авах, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр 2018.01.10-ны өдрийн 39 дугаартай албан тоотоор НӨХГазарт хүргүүлж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулж, 2018.05.15-ны өдрийн 53 дугаартай албан тоотоор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах" журмын маягт-1 хүснэгтээр тус тус хүргүүлж худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж тайлагнасан.	100
		7.9 Нийслэлийн Засаг даргатай контракт гэрээ байгуулж өмчийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж зорилтод түвшинг биелүүлж ажиллах.	Тус байгууллагын 2017 оны гүйцэтгэлийг шалгуулах Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/45 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсгээр дүгнүүлж нийслэлийн Засаг даргын 2018 оны "Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2018 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт"-ыг батлах тухай А/259 дүгээр захирамжийн хавсралтаар байгууллагын Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг батлуулж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж нийт 68,9 сая төгрөгийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хэрэгжүүлж ажилласан.	100
		7.10 НӨХГ болон аж ахуйн нэгжтэй гурвалсан гэрээ байгуулж орлого төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Тус газраас "Төгс илэрхийлэл"ХХК-ний хүнсний дэлгүүрийн зориулалтаар 201701 дугаартай , "Эрхэс туяа"ХХК-ний эмийн сангийн зориулалтаар 201702 дугаартай түрээсийн гурвалсан гэрээг 2018 .04.13-ны өдөр шинэчлэн батлуулж гэрээний дагуу эхний хагас жилд 8.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж ажилласан.	90

	7.11 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, хандиваар бэлтгэгдсэн эд хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд тусгаж, эд хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой бусад асуудлыг нийслэлийн Өмчийн харилцааны газарт тавьж шийдвэрлүүлэн өмчийн нэгдсэн мэдээллийн санд оруулах.	Нийслэлийн Өмчийн харилцааны даргын 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн “Ахмадын хотхон-1”ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай А/230 дугаар тушаалын дагуу 1тэр бум 261,4 сая төгрөгийн хөрөнгийг нийслэлийн Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газарт шилжүүлж өмчийн нэгдсэн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан.	100
	7.12 Газар эзэмших ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлүүлэх дахин үнэлгээ хийлгэх.	Газар эзэмших ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлүүлэх дахин үнэлгээ хийлгэх ажлын бэлтгэл ажлыг хангаж 2018 оны “Байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого, дахин үнэлгээ хийх тухай” А/36 дугаар тушаал гарган 12 дугаар сарын 10-22-ны өдрүүдэд ажиллуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	70
	7.13 ХСУХАТАҮЗЗөвлөлийн олгосон тусгай зөвшөөрлийн гэрээг холбогдох байгууллагаар дүгнүүлэх	ХСУХАТАҮЗЗөвлөлийн олгосон тусгай зөвшөөрөл эзэмших гэрээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр ХСУХАТАҮЗЗөвлөлд хүргүүлж хангалттай үнэлгээтэй дүгнэгдсэн.	100
	8.1 Байгууллага дээр хөтлөгдсөн баримт бичгийг нэр төрөл, хадгалах хугацаагаар нь ангилан, стандартын дагуу үдэж хавтаслан, байгууллагын архивын сан хөмрөгт баяжилт хийх	Удирдлагын баримт бичиг, боловсон хүчний холбогдолтой, үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, санхүүгийн үйл ажиллагааны холбогдолтой баримт бичгүүдийг хадгалах хугацаагаар ангилан стандартын дагуу үдэж хавтаслан байгууллагын архивын сан хөмрөгт 2017 онд нийт 60 баримт бичгийн баяжилтийг хийсэн. 2018 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн нийслэлийн Архивын газрын Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлж архивын сан хөмрөг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна	90
	8.2 Байгууллагын ирсэн, явсан албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй www.edoc.ub.gov.mn цахим хуудсыг хөтлөж цахим засаглалыг хэрэгжүүлж ажиллах.	Байгууллагын нэвтрэх эрхийн дагуу /www.edoc.ub.gov.mn/ цахим хуудсаар 2018.12.10 –ны байдлаар нийт 118 бичиг хүлээн авч, хариутай 34 бичгээс 29 бичгийг хугацаанд нь, 4 бичгийг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн бөгөөд биелэлт 93,9%-тай, гадагшаа нийт 148 бичиг явуулсанаас хариу ирүүлэх ёстой 51, хариугүй 83 бичиг, хариу ирээгүй 44, биелэлт-30%-тай, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 94,79 хувьтай байна.	90

	8.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан бүхий л хэлбэрээр хүлээн авч, иргэддээ шуурхай ил тод нээлттэй шийдвэрлэх	Цахим өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн smartcity.mn программаар манай байгууллагатай хамааралттай иргэдээс ирсэн 3 өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж ажиллсан.	100
	Нийт төлөвлөсөн -53 ажил Хангалттай - 49, Хэрэгжих шадандаа-3 , Хэрэгжилт удаашрилттай-1		91,3

ТАНИЛЦСАН:
ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН



Ц.ОТГОНБАТ

Г.БААТАРХҮҮ